

## ЭРДЭНЭЦАГААН СУМ

### 2022 ОНЫ 8 ДУГААР САРЫН МЭДЭЭ

**Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд: Хатиган 5-р наадам, Таван түмэн адууны баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүллээ.** Хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 17-04-019/18 дугаартай Улсын байцаагчийн зөвлөмжийн дагуу Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хүрээнд хэрэгжилтийг хангуулах заалтууд,

1. Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор хоол, хүнсээр дамжих хордлого халдвараас сэргийлэх, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ирүүлсэн зөвлөмж үүдийг хүлээн авч дараахь ажил арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Үүнд:

Нэг: 17-04-019/18 дугаартай бүхий зөвлөмжөөс өөрийн ажил үүргийн хүрээнд 8-н заалтыг сумын хэмжээнд бэлтгэж сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 1/35 тоот албан бичгээр Хүнс, Худалдаа үйлчилгээ,хоол үйлдвэрлэлийн газруудын эздэд зөвлөмж мэдэгдэл хүргэсэн. Мөн “Сумын өнгө үзэмж тохижилтонд аж ахуйн нэгж байгууллага, үйлчилгээний газруудын үүрэг, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх тухай” 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01 тоот албан даалгавар гарч нийт аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудад хүргэж тогтмол хяналт тавьж сэрэмжлүүлгийг өгч ажиллалаа. Албан хэрэг хөтлөлтийн ажлын хүрээнд Сумын Засаг даргын захирамж 5, албан тоот 6, Тамгын газрын даргын тушаал 7 ирсэн бичиг 14, хариутай бичиг 5, өргөдөл гомдол .3–ийг хүлээн авч ажиллаа. Мөн 2018-2021 оны нийт 66 баримтанд хөмрөгийн дугаар шинээр үүсгэж архивт хадгаллаа. Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан СЗД-н 2022 оны 08 сарын 21 өдрийн А/156-р Хорио цээрийн дэглэм тогтоох тухай захирамж гарч, голомтонд 12 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр** : Мал аж ахуйн улсын зөвлөгөөнд ХАА-н мэргэжилтэн оролцлоо. төлийн мэдээ, хорогдлын мэдээ, үнийн мэдээг 8-н багаас хүлээн авч дээд байгууллагад дамжуулан ажиллаж байна. Сүхбаатар аймагт 12-15 ны өдрүүдэд ХАА-н тариалангийн программын сургалт болж , тариалан эрхлэгчдийн бүртгэл мэдээллийн шинэ цахим программтай болсон. Сумын хэмжээнд 12 тариалан эрхлэгч иргэн, 1 аж ахуйн нэгжийн бүртгэл хийгдсэн. Өнөөдрийн байдлаар 135235 толгой мал төл хүлээн авсан байна. мал төллөлт 73,8 хувьтай байна. нөөцийн мэдээг 1 өдөр бүр дамжуулж байна. Төлийн хорогдол 175 толгой төл мал байна.

**Статистикийн ажлын хүрээнд:** 2022 оны хагас жилийн тайланг Төсөвт 7 байгууллага, Ерөнхий орлого 1, ОНӨҮГазар 1, Сан 2, төрийн оролцоотой ААНэгж 1 нийт 12 газрын тайланг хүлээн авч, төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан. 2023 төсвийн төсөл 2024, 2025 оны төсвийн төсөөлөлийг хугацаанд тушааж fiscal программд шивж ажилласан. Шинээр нээгдсэн 3-н ААНэгжийг Сүхбаатар аймгийн төрийн санд ирсэн хугацаанд хүргүүлсэн. 8-р сарын орлогыг 22-ны өдрөөр тасалбар болгон хааж төвлөрүүлсэн.

№	Орлогын төрөл	Гүйцэтгэл төгрөгөөр
1	Цалин, түүнтэй адилтгах	292,439,877.46
2	Үйл ажиллагааны орлого	3,018,104.16
3	Хөрөнгийн орлого	26,554,701.15
4	Шууд бус орлого	5,554,521.00
5	үл хөдлөх эд хөрөн албан татвар	16,151,040.31
6	Бууны албан татвар	662,000.00
7	Малд ногдуулах албан татвар	89,832,100.00
8	Улсын тэмдэгийн хураамж	3,689,500.00
9	Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	784,500.00
10	Газрын төлбөр	13,255,481.00
11	Байгалийн ургамлын НАТөлбөр	2,811,375.00
12	торгуулийн орлого	18,527,419.52
13	Бусад орлого	10,000,000.00
	<b>Нийт орлого</b>	<b>483,280,619.60</b>

13 Аймаг нийслэлээс авсан татаас 136,815,300.00 нийт **483,280,619.60** төгрөгийн орлого төвлөрч орлогыг хааж, орон нутгийн төсөвт байгууллагад **668,885,148.05** төгрөгийг санхүүжилтийг олгож ажиллаа.

2022 оны 8-р сард төсөвт 9 байгууллагын 2031 ширхэг, 8,244,974,264.27 төгрөгийн гүйлгээ хийж хянаж баталгаажуулан ажиллаа.

**НИЙГМИЙН ДААТГАЛИЙН ХҮРЭЭНД:** А/О-с орох орлогыг 100%-аас дээш төвлөрүүлж төсвийн орлогыг жигд ханган биелүүлсэн. СДД-д давхардсан тоогоор 423 даатгуулагчид үйлчилгээ үзүүлж 43.9 сая төгрөг төвлөрүүлэн ажиллаа. ЭМД-д 86 иргэнд үйлчилгээ үзүүлж 6.1 сая төгрөгийг төвлөрүүлэн ажиллаа.

2022 оны 6,7-р сард шинээр 24 тэтгэвэр тогтоож, ЖБАТ, ХЧТА, оршуулгын тэтгэмж 35 даатгуулагчид үйлчилгээ үзүүлж 32,3 сая төгрөгийг олгож ажилласан байна. Бүртгэл 2022 цахим бүртгэлээр 398 даатгуулагч иргэнд Нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүллээ.

**МЭТ:** Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/145, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 01 албан даалгавар, Сумын Засаг даргын 2022 оны А/95 тоотуудыг удирдлага болгон сэг зэм устгах

ажлыг зохион байгуулан ажиллалаа. Мал эмнэлгийн Ерөнхий газрын дадаалгаврын дагуу Угаалгын ажлыг зохион байгуулан 8 дугаар сарын 10-наас эхлэн 5 малын эмч 5 туслах ажилтантай ажиллаж байна. Угаалганд Бог мал-42731



үхэр-1858 нийт 44589

мал угаалганд хамрагдаад байна. Аймгийн Засаг даргын 2022 оны 8 дугаар сарын 11-ны өдрийн А/467 тоот захирамжаар бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахаар захирамжийг төлөвлөн хуваарийг гарган Аймгийн мал эмнэлгээс вакцинжуулалтыг татан авч байна. Тус сумын нутаг дэвсгэрт малын гоц халдварт” Үхрийн товруутах” өвчин гарч 1 голомтний 22 үхэрт устгал хийгээд байна.

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.